

Булган аймаг Сайхан сумын ЗДТГ-ын дотоод ажлын сарын мэдээ

2015.04.25

Их Хүрэмт

2015 оны 1-р ээлжийн урьдчилсан цэрэг татлага 04 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулагдлаа. Нийт 30 гаруй цэрэг татлагад орлоо.

Өнгөрч буй долоо хоногт цаг агаарын байдал муу байсантай холбоотой малчид, ард иргэдэд шаардлагатай мэдээ мэдээлэл хүргэх ажлыг шуурхай зохион байгуулж ажиллаа.

Мөн төрийн байгууллагуудын албан хэрэгцээнд ABLE программыг ашиглах ажлыг зохион байгуулж сургалт зохион байгууллаа. Эхний ээлжинд бүх хүмүүсийг хаягтай болгож оруулаад дараа нь ЗДТГ-т ажилчдын цагийг нь энэ программаар бүртгэх төлөвлөгөөтэй байна.

Манай суманд хаваржилтын байдал сайжирч, малчид хөдөлмөрчидийн сэтгэл тэнүүн сайхан болж байна.

Цаг агаар сайжирч, ард иргэдийн сэтгэл санаа сайхан болсон учир бид бүхэн малчидынхаа хөдөлмөр бүтээлийн үр дүн болсон “Дөрвөн түмэн адууны баяр”-ыг зохион байгуулах ажлын хэсэг томилогдон ажлуудаа төлөвлөж эхлээд байна.

Дөрвөн түмэн адууны баярын лого батлагдлаа.

Манай сум мэдээлийн ил тод байдал, төрийн үйлчилгээ нээлттэй түргэн шуурхай байх хүрээнд saikhan.bu.gov.mn вэб сайт 2015 оны 04 сарын 27-ны өдрөөс эхлэн ажиллахад бэлэн болоо.

Сумын ИТХ-ын 6 дахь удаагийн сонгуулийн 10 дугаар хуралдааныг 2015 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгууллаа.



Уг хуралдаанаар:

- 2015 оны төсвийн тодотгол
- 2015 онд ОНХСангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний тодотгол
- Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сумын бодлого
- Дөрвөн түмэн адууны баярыг зохион байгуулахтай холбогдуулан суманд хийгдэх 44 бүтээлч ажлын талаар танилцуулж, батлагдлаа.

2015 оны 04 сарын 26-ны Ням гаригт Булган аймгийн баруун бүсийн доод 3 насны хурдан морьдын уралдаан амжилттай зохион байгуулдаж 300 гаруй хурдан хүлэг ирж тоосоо өргөсөн бөгөөд унаач хүүхэд, уралдсан морьд нь гэмтэл бэртэлгүй сайхан наадам болж өнгөрлөө.



Мөн манай суманд Авлигатай тэмцэх газрын шалгалтын ажлын хэсэг ажиллаа.

ЗДТГазар